



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа  
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

# **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

(2026 оны III сар)

## ГАРЧИГ

### **БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ III САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН ..... 3**

<b>1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ .....</b>	<b>3</b>
1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил.....	3
1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ.....	3
1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ .....	4
1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ .....	6
1.1.4. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ .....	6
1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр) .....	7
1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо .....	7
1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт .....	7
1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт .....	7
<b>2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ 9</b>	<b>9</b>
2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ .....	9
2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил .....	9
2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ .....	9
2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр).....	10
<b>3. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА, ЯВУУЛЫН БОЛОН СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ .....</b>	<b>11</b>
3.1. Сургалт сурталчилгаа, явуулын үйлчилгээ .....	11
3.2. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ.....	12
3.3. Хамтын ажиллагаа, зохион байгуулсан бусад ажил.....	12

## **БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ III САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг.

Тус төв нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

2026 оны III сард төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, иргэдэд хүргэсэн төрийн үйлчилгээг (хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон нийгмийн даатгалын чиглэлээр ангилж) энэхүү тайланд дурьдав.

### **1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ**

(Тайлант хугацаа 2026.03.02 - 2026.03.31)

#### **1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2026 оны 03 дүгээр сарын 02-ны өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **340** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал: 30,689,791 вон, нутаг буцах зардал: 6,018,452 вон, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү 7,401,055 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс: 7,740,439 вон зэрэг хэлбэрээр нийт **51,849,737** воныг Монгол Улсын **38** иргэнд (давхардсан тоогоор) олгуулав.

#### **1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ**

- Иргэн О.Б (Е-9) нь хугацаанаасаа өмнө нутаг буцаад эргэж ирэх боломжгүй нөхцөл үүссэн тул ажил олгогчтой холбогдон ажлаас гарах мэдэгдлийг хийлгэж, 13 дахь сарын цалин 6,996,390 вон, нутаг буцах зардал 512,830 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.

- Иргэн Б.Ж (Е-9) нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин 9,769,811 воныг олгуулав.

- Иргэн Д.Г-гийн (Е-9) 13 дахь сарын цалин 2,052,590 вон, нутаг буцах замын зардал 500,000 вон, нийт 2,552,590 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.

- Иргэн Э.П-гийн (Е-9) 13 дахь сарын цалин 7,688,000 вон, нутаг буцах зардал 523,500 вон, нийт 8,211,500 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.

- Иргэн Ц.Б (E-7) нь визний ангиллаа сольсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж нутаг буцах зардал 511,920 воныг олгуулав.
- Иргэн Х.Б (E-9) нь хугацаанаасаа өмнө нутаг буцсан тул нутаг буцах зардал 501,580 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Д.Б-гийн (E-9) нутаг буцах зардал нэхэмжилсэн өргөдлийг Самсунг даатгал руу илгээж 523,000 воныг олгуулсан.
- Иргэн С.Ж-гийн талийгаач нөхөр А.Э-гийн (E-9) нутаг буцах зардал 505,000 воныг Аж үйлдвэр хүний нөөцийн газраас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн О.Х-гийн (E-9) нутаг буцах зардал 523,500 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Б.Д-гийн (E-9) нутаг буцах зардал 367,122 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Б.Э (E-9)-гийн ажлаа солих хүсэлтийг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлэсэн. Тухайн иргэний олгогдоогүй цалингийн үлдэгдэл 1,130,700 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн н.М-ийн (E-9) олгогдоогүй цалин хөлсний маргаантай холбоотой өргөдлийг харьяа Хөдөлмөрийн хэлтэст гарган шийдвэрлүүлж 3,929,739 вон олгуулав.
- Иргэн А.Х (E-9), О.С (E-9), Б.Б (E-9) нарын ажлын байр солих хүсэлтийг хүлээн авч Мугпу Хөдөлмөрийн хэлтэст гомдлыг гарган, ажил олгогчтой тохиролцооноор 2026.03.20-ны өдрөөр хөдөлмөрийн гэрээг цуцлахаар болсон.
- Иргэн Г.Б (E-7) нь махны үйлдвэрт ажиллаж байгаад ажлаас гарсны дараах тэтгэмж буюу үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингаа авч чадаагүй асуудлаар өргөдөл гаргасан. Тооцооллыг хийж ажил олгогчоос нэхэмжилсэн боловч тохиролцоонд хүрч чадаагүй тул өргөдлийг Хөдөлмөрийн хэлтэст (고용노동부 천안고용노동지청) шилжүүлсэн. 2026.03.17-нд өргөдөл гаргагч өөрийн биеэр очиж мэдүүлэг өгсөн.

### **1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ**

- Иргэн П.О-гийн (визгүй) барилгын ажил хийгээд авч чадаагүй цалингийн үлдэгдлийг нэхэмжилж, Хөдөлмөрийн хэлтэст (전주고용노동지청) өргөдөл гарган, 2,680,000 воныг олгуулсан.
- Иргэн А.А-гийн (визгүй) олгогдоогүй цалин 4,901,055 воныг олгуулсан.
- Иргэн Д.С-ийн (визгүй) олгогдоогүй цалин 2,500,000 воныг олгуулан ажилласан.
- Иргэн Б.Б-гийн (визгүй) нутаг буцах замын зардал 500,000 вон болон 13 дахь сарын цалин болох нийт 4,183,000 вон олгуулан ажиллав.
- Иргэн М.Т-гийн (визгүй) хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байхдаа төлсөн нутаг буцах зардлыг Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас (서울남부지사) нэхэмжилж 500,000 вон олгуулсан.
- Иргэн Б.Ж-гийн (визгүй) нутаг буцах зардлыг Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас нэхэмжилж 550,000 вон олгуулсан.
- Иргэн Ч.Ю-гийн (визгүй) 2025.12.18-20-ны өдрүүдэд барилгын нураалт хийсэн ажлын хөлсийг нэхэмжилж Хөдөлмөрийн хэлтэст (의정부지청) өргөдөл гаргасан

боловч өргөдөл гаргагч урт хугацаагаар Монгол явсан тул өргөдөл гаргагчийн хүсэлтээр өргөдлийг хаасан.

- Иргэн М.Ш (визгүй), Н.Б (визгүй) нарын олгогдоогүй цалин 6,800,000 воныг нэхэмжилж Хөдөлмөрийн хэлтэст (안상고용노동지청) өргөдөл гаргасан ба ажил олгогчийн мэдээлэл бүрэн олдохгүй байгаа шалтгаанаар 2026.02.24-ний өдөр өргөдөл гаргагч хүсэлт гаргаж өргөдлийг хаалгасан.

- Иргэн Т.Б (С-3), Л.М (С-3) нар нь 2024.06 дугаар сард Инчон хотод байрлах хоолны газар ажиллаад авч чадаагүй цалингийн маргааныг шийдвэрлүүлэхээр Инчон хотын Хууль зүйн туслалцаа үзүүлэх төвд хандсан. Өргөдөл гаргагчдын хувийн тамга, Хөдөлмөрийн хэлтсийн лавлагааны бичиг, итгэмжлэл зэрэг холбогдох баримт материалыг хүлээлгэн өгөв.

- Иргэн Б.С нь (С-3) 2024.07 дугаар сард хөдөлмөрийн гэрээгээр ..... үйлдвэрт ажиллаж байхдаа үйлдвэрлэлийн осолд өртөж, эмчилгээ хийлгэж дуусаад нутаг буцсан. Улмаар үйлдвэрээс сэтгэл санааны хохирол нэхэмжилсэн ба урьдчилан тохиролцох эсэхийг тодруулсан шүүх хурал ..... хотын орон нутгийн шүүхэд болж, тус төвөөс орчуулгын туслалцаа үзүүлсэн.

- Иргэн Ш.Б-гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлсний өргөдлийг Сөүл баруун бүсийн Хөдөлмөрийн хэлтэст гаргасан ч ажил олгогч нь 2026.03.30-ны дотор олгохоор тохирсон тул өргөдлийг эргүүлэн татах хүсэлт гаргасан.

- Иргэн Р.А (визгүй), Б.Б (визгүй), Г.Б (визгүй), С.А (визгүй), Ш.М (визгүй) нарын 5 хүний цалин хөлс нийт 10,240,000 воныг нэхэмжлэх өргөдлийг Хууль зүйн туслалцааны төвөөр дамжуулан иргэний шүүхэд нэхэмжлэл гарган шүүхийн шийдвэр гаргуулсан. Хөдөлмөр халамжийн хэлтэст төрөөс олгох нөхөн төлбөр олгох хүсэлтийг 2026.03.04-ний өдөр илгээв.

- Иргэн С.О-гийн (визгүй) олгогдоогүй цалин 900,000 воныг нэхэмжилж Хөдөлмөрийн хэлтэст (서울고용노동청) өргөдөл гаргасан. 2026.02.24-ний өдөр өргөдөл гаргагч очиж мэдүүлэг өгсөн ба өөрийн хүсэлтээр өргөдлөө хаалгасан.

- Иргэн Б.Ц-гийн (G-1) олгогдоогүй цалингийн үлдэгдэл болох 5,420,000 воныг нэхэмжилж Хөдөлмөрийн хэлтэст (대구서부고용노동지청) 2026.02.25-ны өдөр өргөдөл гаргасан.

- Иргэн Ц.Т-гийн (визгүй) цалингийн асуудлаар Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газарт өргөдөл гаргахаар шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж байна.

- Иргэн Б.У (визгүй), М.Т (визгүй), Б.О (визгүй), Б.Г (визгүй), С.Б (визгүй), Н.Б (визгүй), Б.А (визгүй), Б.Б (визгүй), Э.У (визгүй), Э.С (визгүй), Б.Б (визгүй), А.О (визгүй) нарын сайн дураар нутаг буцах мэдэгдлийг Цагаачлалын албанд гаргаж, баталгааны хуудсыг өргөдөл гаргагчид илгээв.

- Иргэн С.Э-гийн (визгүй) нутаг буцааж өгөх хүсэлтийг хүлээн авч Монгол буцаах ажлыг Монгол Улсаас БНСУ-д суух ЭСЯ-ны Консулын хэлтэстэй хамтран зохион байгуулж, сайн дураар нутаг буцах хуудсыг гаргаж, сэтгэл зүйчээс сэтгэл зүйн зөвлөгөөг өгч, Монгол буцах хүртэл хяналт тавин ажиллав.

### **1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ**

“Эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулж буй эмч нарын нэгдсэн холбоо” ТББ болон Сөүл хотын "Seoul jump medical center"-тэй хамтран 2026 оны 03 дугаар сард зохион байгуулах үзлэгийн зарыг түгээж, бүртгэл хийсэн. Мөн өмнөх үзлэгт хамрагдсан иргэн П.Д-г 2026.03.17-ний өдөр өвдөгний хагалгаанд ороход мэдээллээр ханган туслалцаа үзүүлж, эмчилгээний зардлыг хөнгөлүүлсэн.

“Монгол хэл бичгийн сургалт”-ыг төвийн байранд үргэлжлүүлэн зохион байгуулах ажлын хүрээнд бүртгэлийн зарыг хүргэж, 2026.03.08-ны өдрөөс 2 ангитайгаар хичээллэж эхлэв.

“Инчон Монгол Бямбын Сургууль”-аас ирсэн хүсэлтийг Боловсролын сайдад уламжилж дэмжлэг хүссэн албан бичгийг хүргүүлсэн.

Иргэн Б.Х нь биет бусаар эмнэлгийн магадалгаанд үндэслэн групп тогтоолгож халамжийн үйлчилгээ авах хүсэлт гаргасан. Тухайн иргэн нь Монголд очиж оношлуулах боломжгүй тул Солонгост оношлуулсан эмнэлгийн баримтыг үндэслэн “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн иргэнийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлж, холбогдох журмын дагуу бүртгэв.

### **1.1.4. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ**

- Хөдөлмөрийн гэрээт ажилчны E-9 визээс ур чадвартай ажиллах хүчний E-7-4 виз руу шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 8 иргэнийг, E-7-4 виз руу шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 2 иргэнийг шинээр бүртгэсэн.
- E-7-4 визний асуудлаар нийт 45 иргэнтэй утсаар болон цахимаар холбогдож бүрдүүлэх баримт бичиг, оноо тоолох, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, жолооны үнэмлэх авах, ажлын байр солих, D-10, F-2, E-7-4R, F-2R ангилал руу өөрчлөх зэрэг асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн.
- E-7-4 визний асуудлаар “E-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа ба гишүүдийн тоо 955 байна. Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор тус сошиал хуудсанд виз сунгуулахад бүрдүүлэх баримт бичиг, E-7 визтэй иргэд солонгосын жолооны үнэмлэхийг шалгалтгүй шууд авах боломжтой тухай, БНСУ-д амьдрахад туслах гарын авлага, 2026 оны гадаадын ажиллах хүч, визийн бодлогын талаарх товч мэдээлэл зэрэг 15 удаагийн мэдээлэл зөвлөгөөг нийтэлсэн.
- E-7-4 визтэй иргэн гэр бүлээ урихад юуг анхаарах вэ? сэдвээр анимейшн видео бэлтгэн, сошиал сувгуудаар түгээсэн.
- Төвийн албан хаагчдад Ур чадвартай ажиллах хүчний E-7-4 визний талаар 2026.02.10-ны өдөр сургалт зохион байгуулж, мэдээлэл өгсөн.

## 1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр)

### 1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо

Тоон мэдээллийн агуулга	Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт		
	Иргэн	Олгуулсан дүн (вон)	
1) Нутаг буцах зардал	12	6,018,452	
2) Цалин, илүү цагийн хөлс	2	5,060,439	
3) Самсунгийн 13 дахь сарын цалин	5	30,689,791	
Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	4) Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө		
	5) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	6) Гэнэтийн ослын даатгал		
	7) Гэнэт халагдсаны тэтгэмж		
	8) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
	9) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	1	
	10) 13 дахь сарын цалин		
	11) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	12) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
	13) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	1	2,680,000
	14) 13 дахь сарын цалин	2	7,401,055
	15) Үйлдвэрлэлийн ослын даатгал		
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	16) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	15	
	<b>Монгол Улсын иргэдэд олгуулсан дүн</b>	<b>38</b>	<b>51,849,737</b>

### 1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	Шийдвэрлэлтийн байдал			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
70	38	28	30	-	12

### 1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

Үйлчилгээ	Тоо
1) Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, нутаг буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	17
2) Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах	21

3) Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, асуудлыг шийдвэрлүүлэх	20
4) Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх	20
5) Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	7
6) Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах	5
7) Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах	1
8) Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр сольсон, гэнэт халагдсан тохиолдолд материалыг бүрдүүлэн, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлүүлэх	5
9) Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх	3
10) Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага: - Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам - Хөдөлмөрийн хэлтэс - Төв бирж - Эрүүл мэндийн газар - Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв - Үндэсний тэтгэврийн алба - Хөдөлмөр, халамжийн газар Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга	20
11) Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын асуудлаар нарийвчилсан мэдээлэл, зөвлөгөө өгөх	11
12) Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах тухай мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх	3
13) Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлүүлэх	5
14) Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах	7
15) Визний ангилал солиулахад (Е9-өөс Е-7-4 виз рүү) оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэхэд мэдээлэл, зөвлөгөөгөөр тусалж, дэмжих	47
16) Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	40
17) Бусад мэдээлэл, зөвлөгөө	53
18) ХурДан төрийн цахим үйлчилгээг хүргэх	55
	Утсаар 196
	Цахимаар 68
	Танхимаар 76
<b>Нийт</b>	<b>340</b>
Хүргэсэн үйлчилгээний тоо	

## **2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ**

(Тайлан хамарсан хугацаа 2026.03.01 - 2026.03.31)

### **2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ**

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх үйл ажиллагаа:

- 1) Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс 37 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 34 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 4 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 32 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 70 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

- 2) БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс 52 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 27 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 4 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 19 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 50 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

### **2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил**

Тайлант хугацаанд тус тасаг 297,710,293.00 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 71 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 96,828,385.83 төгрөгийн орлогыг БНСУ-ын 3 банкны сангийн харилцах данснаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банкин дахь төвлөрүүлэх дансанд бүрэн шилжүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2026 оны 03 дугаар сард нийт 78 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 60,960,841.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 37 даатгуулагчийн 27,054,520 төгрөг, сайн дурын даатгалын 41 даатгуулагчийн 33,906,321.00 төгрөг байна.

### **2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ**

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдийг зөвлөгөө мэдээллээр дэмжих, өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1) Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах, орчуулга хийх зэрэг зөвлөгөө мэдээллийг утас, цахим, танхимаар нийт 407 иргэн, даатгуулагчид үйлчилгээ үзүүлсэн.

- 2) БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 1 ээлжийн 4 иргэний 12,367,320.00 вон нэхэмжилсэн хүсэлтийг холбогдох бичиг баримтын хамт тус улсын Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлсэн.
- 3) 2026.03.11-ний өдөр Сөүл хотын Гадаад иргэдийг дэмжих төвийн үйл ажиллагаатай танилцаж, Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, төсөл хөтөлбөрт хамруулах зэргээр цаашид идэвхтэй хамтран ажиллахаар санал солилцсон.
- 4) 2026.03.29-ний Ням гарагт “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль” сэдвээр цахим сургалт хийж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай ойлголт, төрөл, өндөр насны тэтгэврийг нас харгалзахгүйгээр тогтоодог онцлог тохиолдлууд, тэтгэвэр авах эрх, тогтоолгох нас, хугацааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөгөө өгч танилцуулсан. Сургалтад 8 иргэн цахимаар, 10 иргэн танхимаар, нийт 18 иргэн хамрагдав.
- 5) БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн амьдарч оршин суух нөхцөл, ажил эрхлэлт, нас хүйс болон нийгмийн даатгалд даатгуулсан байдал, нийгмийн даатгалын талаарх ойлголт хэр зэрэг байгааг танин мэдэх зорилгоор 71 иргэнээс судалгаа авсан.

#### 2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

	Үйлчилгээ	Тоо	Өссөн дүнгээр
1.	Даатгалд шинээр хамруулсан	Албан журмын даатгал	37
		Сайн дурын даатгал	52
2.	Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Албан журмын даатгал)	Шинээр	32
		Дахин	4
		Хугацаа сунгасан	34
3.	Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Сайн дурын даатгал)	Шинээр	19
		Дахин	4
		Хугацаа сунгасан	27
4.	Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт	Албан журмын даатгал	116,361,600.00 45%
		Сайн дурын даатгал	181,348,693.00 112%
		Нийт	297,710,293.00 71%
5.	Гурав болон түүнээс дээш сарын шимтгэлийн авлага барагдуулалт	Албан журмын даатгал	27,054,520.00
		Сайн дур	33,906,321.00
6.	БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын буцаан олголт	Нэхэмжилсэн	12,367,320.00
		Олгосон	0
		Буцаан олголт авсан хүний тоо	0
7.	Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл	Утсаар	342
		Цахимаар	17
		Танхимаар	48

### **3. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА, ЯВУУЛЫН БОЛОН СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

#### **3.1. Сургалт сурталчилгаа, явуулын үйлчилгээ**

Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 33, youtube сувагт 3, төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн [gov.mn](http://gov.mn) болон [control.e-mongolia.mn](http://control.e-mongolia.mn) веб сайтуудад 24 мэдээ, байгууллагын [seoulcenter.mlsp.gov.mn](http://seoulcenter.mlsp.gov.mn) цахим хуудсанд 33 мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилсан бөгөөд иргэд нийт 231,683 удаа хандсан байна.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 27 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2026.03.09-ны өдөр цахимаар, ирсний дараах сургалтыг 2026.03.12-ны өдөр 27 иргэнийг хамруулан Ёжү, Инчон, Ичоны сургалтын төвд танхимаар тус тус зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга;
- Цалин хөлс тооцох, ажлын байр солихтой холбоотой хууль, дүрэм, журам;
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай;
- Монгол Улсын нийгмийн даатгалын холбогдох хууль тогтоомж;
- БНСУ-ын Үндэсний тэтгэврийн тухай хууль;
- “Нийгмийн хамгааллын тухай” хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн тухай;
- Солонгос улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай;
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйлс;
- Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл;
- Ур чадвартай ажиллах хүчний E-7-4 визний тухай;
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь;
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал зэрэг болно.

Сургалтад барилгын салбарын 9, үйлчилгээний салбарын 3, үйлдвэрлэлийн салбарын 15, нийт 27 хөдөлмөрийн гэрээт иргэн хамрагдав.

Гуанжү хотод 2026.02.28-ны өдөр зохион байгуулсан явуулын үйлчилгээнд БНСУ-д суугаа Элчин сайдын яам, Бусан хотод суугаа Консулын газар, Төрийн банк, 4 банк бус санхүүгийн байгууллага, Гуанжү хотын Монгол-Солонгосын соёлын төв зэрэг байгууллагуудтай хамтран оролцсон. Энэ үеэр 8 иргэнд хөдөлмөрийн харилцаатай холбоотой зөвлөгөө мэдээллийг хүргэж 50 иргэнд гарын авлага түгээн ажиллав.

2026.03.29-ны өдөр БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн “Галил Монгол” сүмд явуулын үйлчилгээг хүргэж, 60 иргэнд төвийн үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлт болоод нийгмийн даатгалын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, тэтгэмжийн тухай хууль, YOMШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулиудыг танилцуулж, 47 тараах материал тарааж, 1 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

### **3.2. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ**

Тайлант хугацаанд 40 иргэнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Тусламж үйлчилгээ авсан иргэдийг тулгамдсан асуудлаар нь ангилж үзвэл сэтгэл гутралын асуудалтай 4, сэтгэл түгшилттэй 4, гэр бүлийн асуудалтай 2, үл ялих байдал (бодол, үйлдэл) 1, бусад шалтгаантай 29 иргэн байна.

2026 оны 3 дугаар сард хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар шинээр ирсэн 15 иргэнд нойргүйдэл илрүүлэх сорил, сэтгэл гутралын болон сэтгэл түгшилтийн сорил хийж, дүгнэлт гаргав. Үүнд:

- Нойргүйдэл илэрсэн 7 иргэн (20-29 нас), 3 иргэн (30-39 нас);
- Сэтгэл түгшилтийн завсрын байдалтай 2 иргэн (20-29 нас);
- Сэтгэл гутралын завсрын байдалтай 1 иргэн (20-29 нас) байна.

“Өсвөр насны хүүхдэд тулгамдаж буй сэтгэлзүйн асуудлыг шийдвэрлэх нь” сэдэвт цахим сургалтыг 2026.03.15-ны өдөр СЭМҮТ-ийн зөвлөх эмч, Анагаах ухааны доктор, клиникийн профессор В.Баярмаатай хамтран зохион байгуулж, өсвөр насны хүүхдийн сэтгэлзүйн онцлог, түгээмэл тохиолддог сэтгэлзүйн асуудал, тэдгээрийн шинж тэмдэг, эцэг эхчүүд хэрхэн зөв ойлгож дэмжих талаар мэргэжлийн зөвлөгөө өгсөн. Сургалтад 33 иргэн оролцсоны 45.5 хувь нь Сөүл хотоос, 54.5 хувь нь бусад хотоос хамрагдсан.

Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай холбоотой видео бичлэг хийж, төвийн цахим хуудсанд байршуулан түгээв.

Ажлын байрны стрессээс сэргийлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх (картын аргаар бүлгийн сэтгэл зүйг тодорхойлох) сэдэвт сургалтад төвийн албан хаагчдыг хамруулав.

“Iwoman” МЭХ-ны БНСУ дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан арга хэмжээнд тус төвийн сэтгэл зүйч “Сэтгэл эрхтэн үү?” сэдвээр илтгэл танилцуулсан. Энэ үеэр хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалын чиглэлээр арга хэмжээнд оролцсон 40 иргэнд зөвлөгөө өгч, гарын авлага хүргэж ажиллав.

### **3.3. Хамтын ажиллагаа, зохион байгуулсан бусад ажил**

2026.03.09-ний өдөр Сөүл хотын Жүнгү дүүргийн цагдаагийн хэлтсийн Олон нийтийн аюулгүй байдал, мэдээллийн тасгийн сурталчилгаа, мэдээлэл хариуцсан албан хаагчтай уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар Монгол улсын иргэдийн аюулгүй байдлыг хангах, хууль бусаар оршин сууж буй иргэн гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд нууцыг хамгаалах, Цагаачлалын албанд мэдэгдэхгүй байх талаар мэдээллийг хүргэж цаашид хамтран ажиллахаар тохиролцов.

Төвийн удирдлага, албан хаагчид 2026.03.11-ний өдөр Сөүл хотын Гадаад иргэдийн төвд зочлон үйл ажиллагаатай нь танилцав. Тус төвийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, уулзалтаар Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, төсөл хөтөлбөрт хамруулах зэргээр цаашид идэвхтэй хамтран ажиллахаар санал солилцсон.

2026.03.13-ны өдөр БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газрын удирдлагуудтай албан уулзалт зохион байгуулав. Уулзалтад тус төвийн дарга Б.Жаргалмаа, БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газрын Олон

улсын ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий газрын дарга Им Синь Мүг, Гадаад ажиллах хүчний газрын дарга Пак Жон Үг болон Гадаад ажиллах хүчний бодлого төлөвлөлтийн хэлтсийн дэд дарга Пак Мин Жон нар оролцов. Тус уулзалтаар БНСУ-д хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны дагуу ажиллаж буй Монгол иргэдийн (Е-9) эрх ашгийг хамгаалах, ажиллах хүчний квотыг нэмэгдүүлэх, нутаг буцаж буй иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулах асуудлаар санал солилцсон. Уулзалтын үр дүнд хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлж, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн эрх ашгийг хамгаалах тал дээр идэвхтэй хамтран ажиллахаар тохиров.

БНСУ-д үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын төрийн болон төрийн өмчит байгууллагын ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “ЭРҮҮЛ МЭНД-ЭВ НЭГДЭЛ 2026” спорт өдөрлөг зохион байгуулах талаар тус төв санаачилж, холбогдох байгууллагуудад албан тоот хүргүүлсэн.

Үүрэн телефон холбооны “КТ” компанийн монгол борлуулагч “Ubmobile” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Сөүл хотын Жүнгү дүүрэгт байрлах, монгол иргэдийн олноор цугладаг “Монгол таун” үйлчилгээний төвийн 3 давхарт төвийн үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллахаар болж, бэлтгэл ажлыг ханган, үйл ажиллагааг эхлүүлэв.

LDS сүмийн дэргэдэх Дезерет олон улсын байгууллагатай 2026.02.26-ны өдөр уулзаж Солонгост оршин сууж буй хөгжлийн бэрхшээлтэй Монгол иргэдэд нэн шаардлагатай байгаа зүйлсийн жагсаалтыг гаргаж хүргүүлэхээр болов.

Шинээр ирсэн гэрээт ажилчдын судалгаа, ур чадвартай ажилчдын судалгаа, нутаг буцаж буй иргэдийн судалгааны мэдээллийн санг тус тус шинэчилсэн.

Байгууллагын сошиал хуудасны чатботын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор мэдээлэл бүрэн авч дууссан 181 иргэний харилцсан мессежийг устгав. Чатботод байршуулсан хөдөлмөрийн харилцаанд холбогдох 12 мэдээллийг шинэчлэн боловсруулав.

ХХҮЕГ-аас ирүүлсэн 01/190 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй иргэдийг нисэх буудлаас тосож буй үйл явц, ирсний дараах сургалтад хэрхэн хамрагддаг болохыг дүрсжүүлэн, илгээсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01, 04 дүгээр Албан даалгаврын хэрэгжилтийг 2026.02.27-ны 1/33 дугаар албан бичгээр ХХҮЕГ-т хүргүүлэв.

- - - оОо - - -